



МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 2/01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсгийг үндэслэн тус тус ТУШААХ нь:

- Биеийн тамир, спортын арга хэмжээний зохион байгуулалтын журам, жишиг баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын алба (Э.Тэмүүжин)-д үүрэг болгосугай.

Монгол улсын сайд, Олимп,  
нийтийн биеийн тамир, спортын  
Үндэсний хорооны дарга

Б.БАТ-ЭРДЭНЭ



000001

Олимп, нийтийн биеийн тамир, спортын  
Үндэсний хорооны даргын  
2023 оны 11. дүгээр сарын 11-ны өдрийн  
Ажлын тоот тушаалын Нэгдүгээр хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЖУРАМ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

О.Баттулга      Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,

Гишүүд:

Б.Нямсүрэн      Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга,

О.Баасан      Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга,

С. Мөнх-Эрдэнэ      Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн,

Б.Өлзийбаяр      Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн,

Г.Бямбасайхан      Нийслэлийн биеийн тамир, спорт газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

В.Дуламсүрэн      Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны мэргэжилтэн,


Ю.Батсайхан      Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ахлах мэргэжилтэн,

У.Дөлгөөнбаяр      Монголын үндэсний олимпын хорооны Спортын холбоод асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр),

Д.Сүрэнхорлоо      Монголын үндэсний Паралимпын хорооны дэд ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр),

Нарийн бичгийн дарга:

Э.Алтанзул      Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албаны мэргэжилтэн,


 Олимп, нийтийн биеийн тамир, спортын  
 Үндэсний хорооны даргын  
 2023 оны 11 дугаар сарын 11 -ны өдрийн  
 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ БАЙГУУЛАЛТЫН ЖУРАМ,  
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах ажилтан	Хяналт тавих албан тушаалтан
1	Журам, баримт бичиг боловсруулахтай холбогдуулан эрх зүйн орчин бүрдүүлэх боломж, саналыг нэгтгэн танилцуулах,	XII/25	С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул Б.Өлзийбаяр	Э.Тэмүүжин
2	Тэмцээний зохион байгуулалтын журам, жишиг баримт бичгийн төслийг боловсруулах,	XII/01-XII/30	С.Мөнх-Эрдэнэ Б.Нямсүрэн Ю.Батсайхан	О.Баттулга
3	Журам, жишиг баримт бичгийн төслийг аймаг, дүүргийн биеийн тамир, спортын хороодын төлөөлөлд хэлэлцүүлэх, ярилцлага зохион байгуулах, санал нэгтгэх,	2023 оны I/10-20	Б.Нямсүрэн Ю.Батсайхан	О.Баттулга
4	Журам, жишиг баримт бичгийн төслийг төрийн бус байгууллага, спорт холбоодын төлөөлөлд хэлэлцүүлэх, ярилцлага зохион байгуулах, санал нэгтгэх,	2023 оны I/10-25	С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул У.Дөлгөөнбаяр Д.Сүрэнхорлоо	О.Баттулга
5	Журам, жишиг баримт бичгийн төслийг олон нээлттэй байршуулах санал авах нэгтгэх,	2023 оны I/20-25	Б.Нямсүрэн С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул	О.Баттулга
6	Ажлын хэсэгт төслийг эцсийн байдлаар хэлэлцүүлэх,	2023 оны II/10-15	С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул	Э.Тэмүүжин
7	Тэмцээний зохион байгуулалтын журам, жишиг баримт бичгийн төслийг боловсруулалт, хяналтын эцсийн шатанд шилжүүлэх,	2023 оны II/15-20	С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул Б.Өлзийбаяр	Э.Тэмүүжин
8	Тэмцээний зохион байгуулалтын журам, жишиг баримт бичгийг батлуулах,	2023 оны II/25-III/02	О.Баттулга Б.Нямсүрэн С.Мөнх-Эрдэнэ Б.Алтанзул	Э.Тэмүүжин



Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын  
2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн  
тоот тушаалын Гуравдугаар хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Тус ажлын хэсэг нь Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын баталсан бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

### Нэг. Нийтлэг журам

1. Ажлын хэсгийн шийдвэр гаргах үйл ажиллагаа хуралдаан байна.
2. Хурлыг гишүүдийн 50-с доошгүй хувийн бүрэлдэхүүнтэй хийнэ.
3. Цаг үеийн тулгамдсан асуудал шийдвэрлэх шаардлагатай асуудлаар тухай бүр ажлын хэсгийн дарга хурлыг зарлан хуралдуулж болно.
4. Ажлын хэсгийн дарга эзгүйд чухал хэрэгтэй бол нарийн бичиг удирдан явуулж болно. Хэлэлцэж буй асуудлаар хорооны гишүүдийн олонхын саналыг үндэслэн эцсийн дүгнэлт хийж, хурлын шийдвэр, тогтоол, тэмдэглэл гаргана.
5. Хуралдааныг цахим болон танхим гэсэн хэлбэрээр зохиож болно.
6. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн даргаар хянуулж гарын үсэг зурж баталгаажуулна.
7. Хурлаар хэлэлцэх асуудлыг нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан тарааж танилцуулан бэлтгэлийг хангана.
8. Гишүүдийн ажлын хуваарь:
  - Удирдлага зохион байгуулалт,
  - Төлөвлөлт, боловсруулалт,
  - Хэлэлцүүлэг, хурал, уулзалт
  - Зөвлөмж, дүгнэлт,
9. Гишүүд энэхүү ажлын чиглэлийн хуваарийн дагуу төлөвлөгөөнд заагдсан ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.

### Хоёр. Ажлын хэсгийн гишүүдийн ажлын хуваарь

- 2.1 Дарга:
  - Үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
  - Үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийн явц, төлөвлөгөөний биелэлт хангах;
  - Ажлын хэсгийн хурал зарлах, хуралдуулах;
  - Ажлын хэсгийн үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх;
- 2.2 Хорооны гишүүд:
  - Хариуцсан ажил, үүргийг цаг тухайд нь хийх, зохион байгуулан гүйцэтгэх;
  - Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай ажиллах;
  - Төлөвлөлт, боловсруулалтад хамтран ажиллах;
- 2.3 Нарийн бичгийн дарга:
  - Ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлэх;
  - Ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, мэдээллээр хангах;
  - Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын боловсруулалт хийх;
    - Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн ажилтан болон мэдээллийн хэрэгслүүдэд байнга өгч байх;